

**БУЛГАН АЙМГИЙН 2024 ОНЫ 3 САРЫН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2024-04-08

Булган

2024 оны 3 сарын байдлаар нийт орлого ба тусламжийн дүн **22,0** тэрбум төгрөг буюу 1119,2 хувийн, нийт зарлага **14,2** тэрбум төгрөг буюу 56,2 хувийн гүйцэтгэлтэй байна.

1. Төсвийн орлого

Нийт орлого ба тусламжийн дүн **22,0** тэрбум төгрөг буюу **119.2** хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 4,7 тэрбум төгрөг буюу 27,0 хувь, урсгал орлого 2,8 тэрбум төгрөгөөр буюу 19,9 хувиар өссөн байна. Урсгал орлогын гүйцэтгэл **16,9** тэрбум төгрөг буюу **126,7** хувь байна.

(сая төг)

Орлогын нэр төрөл	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	хэмнэлт/хэтрэлт (Тайлант үеийн)		хэмнэлт/хэтрэлт /Өмнөх оны мөн үетэй	
		жилээр	тайлант үе /өссөн дүнгээр/		зөрүү	Хувь, %	зөрүү	Хувь, %
1	2	3	4	5	(4-5)	(5:4)	(5-2)	(5:2)
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	17,327.2	79,315.2	18,454.3	22,003.2	(3,548.9)	119.2	4,676.0	127.0
Урсгал орлого	14,033.9	54,643.1	13,307.5	16,856.4	(3,548.9)	126.7	2,822.5	120.1
Татварын орлого	13,205.1	49,517.9	12,256.0	15,627.1	(3,371.1)	127.5	2,422.1	118.3
Татварын бус орлого	828.8	5,095.2	1,044.0	1,200.5	(156.5)	115.0	371.6	144.8
Хөрөнгийн орлого	28.0	30.0	7.5	28.8	(21.3)	384.5	0.9	103.1
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шил	3,265.3	24,672.0	5,146.8	5,146.8	(0.0)	100.0	1,881.5	157.6
ОНХНСангаас шилжүүлсэн орлого	1,172.0	13,601.6	2,379.2	2,379.2	(0.0)	100.0	1,207.2	203.0
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	2,093.4	11,070.4	2,767.6	2,767.6	-	100.0	674.2	132.2

Нийт орлогын 23,4 хувийг тусламж санхүүжилтийн орлого, 71.0 хувийг татварын орлого, 5,6 хувийг татварын бус орлого эзэлж байна. Үүнээс ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 10,2 тэрбум төгрөг буюу татварын орлогын 46,5 хувийг бүрдүүлсэн байна.

Сумдын хувьд төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **6,8** тэрбум төгрөг буюу **106,4** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: татварын орлогыг сумаар авч үзвэл:

(сая төг)

д/д	Сумын нэр	2024 он төлөв.	2024 он 21 сар төлөв.	2024 он 2 сар гүйц.	зөрүү	хувь, %
1	Баян-Агт	571	53.4	89.4	-36	167.4
2	Баяннуур	443.8	72	73.3	-1.3	101.8
3	Бугат	391.2	35.7	89.4	-53.7	250.4
4	Булган	6574.8	793.5	1401.9	-608.4	176.7
5	Бүрэгхангай	2251.5	204.4	128.2	76.2	62.7
6	Гурванбулаг	501.8	44.1	88.9	-44.8	201.6
7	Дашинчилэн	411.6	48	97.9	-49.9	204.0
8	Могод	419.1	38.9	67.1	-28.2	172.5

9	Орхон	799.4	52.7	90.5	-37.8	171.7
10	Рашаант	1155.9	117.8	392.6	-274.8	333.3
11	Сайхан	510.5	38.8	169	-130.2	435.6
12	Сэлэнгэ	574.8	81.3	111.2	-29.9	136.8
13	Тэшиг	1007	95.5	197.2	-101.7	206.5
14	Хангал	3515.8	561.2	754.9	-193.7	134.5
15	Хишиг-Сндер	531.9	49.6	109.5	-59.9	220.8
16	Хутаг-Сндер	1348.1	174.9	127.9	47	73.1
17	Хялганат	561	91.9	116.8	-24.9	127.1
	СУМЫН ДҮН	21,569.2	2,553.7	4,105.7	-1552	160.8
18	Аймгийн орлого	29,940.4	5,143.0	6,423.5	-	124.9
	НИЙТ ОРЛОГО	51,509.6	7,696.7	10,529.2	-2833	136.8

Аймгийн дүнгээр авч үзвэл хувь хүний орлогын албан татвар, хадгаламжийн хүүгийн орлого, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, ус рашааны нөөц ашигласны төлбөр, торгуулийн орлого, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулсны орлого биелжээ. Баяннуур, Бүрэгхангай, Хангал, Хутаг-Өндөр сумаас бусад сумдын татварын орлогын төлөвлөгөө биелсэн байна. Эрдэнэс таван толгой ХК-ний хувьцаа эзэмшигч иргэдэд олгосон ногдол ашгийн 10%-ийн орлогын албан татвар орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

2. Төсвийн зарлага

Аймгийн төсвийн нийт зарлага **14,227.2** сая төгрөг буюу **56,2** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал **11,021.9** сая төгрөг буюу **50,7** хувь, орон нутаг дахь улсын төсвийн байгууллагын тогтмол зардал **3,205.4** сая төгрөг буюу **89.4** хувь байна.

Аймгийн Авто замын сангийн гүйцэтгэл 1,0 сая төгрөг буюу 16,0%, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 297.0 сая төгрөг буюу 23,8%, Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл 235,9 сая төгрөг буюу 19,1%, аймгийн Байгаль хамгаалах сангийн гүйцэтгэл 379.5 сая төгрөг буюу 26,8% байна.

3. Төсвийн өглөг, авлага

Нийт өр 16,7 сая төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4,1 сая, өмнөх сартай харьцуулбал 6,9 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС